



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2022/174/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баруун-Урт 2022 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор: Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

ᠰᠤᠬᠤᠪᠠᠭᠠᠲᠤ ᠠᠶᠢᠮᠦᠨ ᠨᠢᠶᠦᠭᠡᠮᠡᠨ ᠳᠠᠭᠲᠤᠭᠠᠯᠢᠨ ᠰᠠᠩᠭᠢᠨ 2021 ᠤᠨ ᠰᠠᠨᠬᠡᠭᠦᠭᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠠᠨ, ᠲᠥᠰᠪᠢᠶᠢᠨ ᠭᠦᠢᠴᠡᠲᠦᠭᠡᠯᠢᠭᠡᠨ  
тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
П.АМАР ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.НАРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,593,201,222.93	9,940,607,259.20
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,242,459,674.43	5,797,638,970.55
3	Банканд байгаа бэлэн мөнгө	4,242,459,674.43	5,792,598,970.55
4	Төгрөг	4,242,459,674.43	5,792,598,970.55
5	Төрийн сангийн харилцах	2,048,986.00	398,986.41
6	Арилжааны банк дахь харилцах	4,240,410,688.43	5,792,199,984.14
7	Замд яваа мөнгөн хөрөнгө		5,040,000.00
8	АВЛАГА	3,333,568,191.68	4,127,505,997.61
9	Төлбөртэй үйлчилгээний авлага	269,640,853.35	344,093,185.51
10	Татаас, санхүүжилтийн авлага	3,040,213,627.15	3,769,808,666.47
11	Бусад авлага	23,713,711.18	13,604,145.63
12	Байгууллагаас авах авлага	23,713,711.18	13,604,145.63
13	БАРАА МАТЕРИАЛ	17,173,356.82	15,462,291.04
14	Хангамжийн материал	17,173,356.82	15,462,291.04
15	Бичиг хэргийн материал	1,088,145.00	3,594,390.00
16	Аж ахуйн материал	11,408,694.10	10,572,244.10
17	Түлш, шатах тослох материал		0.11
18	Бусад хангамжийн материал	4,676,517.72	1,295,656.83
19	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	523,439,106.02	507,339,798.43
20	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	523,439,106.02	507,339,798.43
21	Биет хөрөнгө	506,111,106.02	490,011,798.43
22	Барилга, байгууламж, орон сууц	454,927,816.14	454,927,816.14
23	Хуримтлагдсан элэгдэл	- 23,198,021.42	- 34,797,032.14
24	Авто-тээврийн хэрэгсэл	69,900,000.00	69,900,000.00
25	Хуримтлагдсан элэгдэл	- 69,876,900.00	- 69,876,900.00
26	Машин тоног төхөөрөмж(компьютер)	122,947,183.38	69,030,966.18
27	Хуримтлагдсан элэгдэл	- 83,476,971.54	- 26,377,861.21
28	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,273,900.00	74,889,900.00
29	Хуримтлагдсан элэгдэл	- 42,439,223.41	- 49,488,413.41
30	Бусад үндсэн хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00
31	Хуримтлагдсан элэгдэл	- 2,946,677.13	- 3,196,677.13
32	Биет бус хөрөнгө	17,328,000.00	17,328,000.00
33	Бусад биет бус хөрөнгө	17,328,000.00	17,328,000.00
34	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,116,640,328.95	10,447,947,057.63
35	НИЙТ ӨР ТӨЛБӨР	233,665,640.18	168,414,499.35
36	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	233,665,640.18	168,414,499.35
37	Өглөг	63,157,904.71	19,167,922.86
38	Ажилчидтай холбогдсон өглөг	332.10	
39	Бараа үйлчилгээний зардлын өглөг	63,085,921.87	19,094,669.36
40	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		1,602.76
41	Бусад өглөг	71,650.74	71,650.74
42	Байгууллагад төлөх өглөг	71,650.74	71,650.74
43	Урьдчилж орсон орлого	170,507,735.47	149,246,576.49
44	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	170,507,735.47	149,246,576.49
45	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,882,974,688.77	10,279,532,558.28
46	Засгийн газрын хувь оролцоо	7,882,974,688.77	10,279,532,558.28
47	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	304,205,531.58	304,205,531.58

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

48	Хуримтлагдсан үр дүн	7,497,039,258.93	9,893,597,128.44
49	Өмнөх үеийн үр дүн	1,732,096,754.81	7,496,828,113.92
50	Тайлант үеийн үр дүн	5,764,942,504.12	2,396,769,014.52
51	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	81,729,898.26	81,729,898.26
52	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,116,640,328.95	10,447,947,057.63

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	53,130,077,443.44	51,891,788,885.68
2	ТАТВАРЫН ОРЛОГО	22,391,381,510.05	25,532,014,443.69
3	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	22,391,381,510.05	25,532,014,443.69
4	Тэтгэврийн даатгалын шимтгэл	15,882,854,671.85	18,461,998,177.19
5	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,510,851,119.88	1,635,278,880.97
6	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,088,982,681.23	1,208,343,544.09
7	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	278,739,280.44	304,598,154.82
8	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	3,629,953,756.65	3,921,795,686.62
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,881,154.01	62,451,870.99
10	Нийтлэг татварын бус орлого	82,881,154.01	62,451,870.99
11	Хувьцааны ногдол ашиг	0	0
12	Хүүгийн орлого	65,135,287.96	8,322,375.19
13	Торгуулийн орлого	0	0
14	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,805,241.51	12,601,803.00
15	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,232,141.51	12,080,703.00
16	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	573,100.00	521,100.00
17	Бусад орлого	10,940,624.54	23,600,955.00
18	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	17,926,737.80
19	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,655,814,779.38	26,297,322,571.00
20	Улсын төвлөрсөн төсвөөс	346,600,000.00	0
21	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	346,600,000.00	0
22	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,120,000.00	6,437,500.00
23	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	6,152,500.00
24	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,120,000.00	285,000.00
25	Төсвийн захирагчдаас	29,735,743,179.38	25,738,977,171.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,735,743,179.38	25,738,977,171.00
27	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	570,351,600.00	551,907,900.00
28	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	570,351,600.00	551,907,900.00
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	47,365,134,939.32	49,495,019,871.16
30	УРСГАЛ ЗАРДАЛ	47,365,134,939.32	49,495,019,871.16
31	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	586,107,303.24	582,086,863.72
32	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	396,257,697.74	401,257,683.51
33	Үндсэн цалин	311,710,084.74	319,670,926.51

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

34	Нэмэгдэл	64,771,613.00	61,810,757.00
35	Унаа хоолны хөнгөлөлт	14,376,000.00	14,376,000.00
36	Урамшуулал	5,400,000.00	5,400,000.00
37	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,311,483.00	51,832,813.02
38	Тэтгэврийн даатгал	33,009,106.72	35,863,123.33
39	Тэтгэмжийн даатгал	4,078,059.64	3,991,126.60
40	ҮОМШӨ-ний даатгал	3,259,489.03	3,192,901.28
41	Ажилгүйдлийн даатгал	813,639.47	798,225.32
42	Эрүүл мэндийн даатгал	8,151,188.14	7,987,436.49
43	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,640,149.00	37,420,758.45
44	Гэрэл, цахилгаан	2,505,049.00	2,318,381.35
45	Түлш, халаалт	32,917,500.00	33,001,617.10
46	Цэвэр, бохир ус	2,217,600.00	2,100,760.00
47	Байрны түрээс	0	0
48	Хангамж, бараа материалын зардал	19,687,057.00	17,690,139.40
49	Бичиг хэрэг	4,903,290.00	2,046,812.00
50	Тээвэр, шатахуун	7,780,600.00	7,780,499.89
51	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,488,932.00	4,337,951.51
52	Ном, хэвлэл	0	0
53	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,000.00	189,999.00
54	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,319,235.00	3,334,877.00
55	Эд хогшил, урсгал засварын зардал	2,659,030.00	5,652,127.28
56	Багаж, техник, хэрэгсэл	725,100.00	1,499,977.28
57	Урсгал засвар	1,933,930.00	4,152,150.00
58	Томилолт, зочны зардал	1,046,000.00	2,432,000.00
59	Дотоод албан томилолт	1,046,000.00	2,432,000.00
60	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0
61	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,983,602.92	27,010,296.69
62	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,715,633.00	17,685,003.74
63	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,400,000.00	0
64	Даатгалын үйлчилгээ	1,049,988.00	1,044,867.00
65	Тээврийн хэрэгслийн татвар	112,800.00	25,080.00
66	Газрын төлбөр	207,936.00	103,968.00
67	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,733,520.00	4,964,430.00
68	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,763,725.92	3,186,947.95
69	Бараа үйлчилгээний бусад зардал	48,522,283.58	38,791,045.37
70	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,554,850.00	2,285,000.00
71	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,967,433.58	36,506,045.37
72	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,779,027,636.08	48,912,933,007.44
73	Бусад урсгал шилжүүлэг	41,321,153,420.00	43,778,312,590.00
74	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	41,282,134,320.00	43,765,295,707.00
75	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,149,500.00	12,130,183.00

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

76	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,869,600.00	886,700.00
77	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,457,874,216.08	5,134,620,417.44
78	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,457,874,216.08	5,134,620,417.44
79	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	5,764,942,504.12	2,396,769,014.52
80	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	5,764,942,504.12	2,396,769,014.52

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

№	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	1,704,858,419.06	2,090,793,848.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			27,238,335.75	27,238,335.75
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	1,732,096,754.81	2,118,032,184.65
4	Тайлант үеийн үр дүн			5,764,942,504.12	5,764,942,504.12
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	7,497,039,258.93	7,882,974,688.77
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	7,497,039,258.93	7,882,974,688.77
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-211,145.00	-211,145.00
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	7,496,828,113.93	7,882,763,543.77
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			-0.01	-0.01
10	Тайлант үеийн үр дүн			2,396,769,014.52	2,396,769,014.52
11	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	304,205,531.58	81,729,898.26	9,893,597,128.44	10,279,532,558.28

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	50,294,011,678.99	51,122,248,382.06
2	ТАТВАРЫН ОРЛОГО	19,851,945,027.55	24,706,313,743.39
3	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	19,851,945,027.55	24,706,313,743.39
4	Тэтгэврийн даатгалын шимтгэл	13,933,351,287.63	18,132,986,104.48
5	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,243,769,034.07	1,425,008,395.74
6	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	794,893,008.10	969,054,553.98
7	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	231,962,180.10	266,626,701.42
8	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	3,647,969,517.65	3,912,637,987.77
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	168,135,051.44	74,129,838.67
10	Нийтлэг татварын бус орлого	168,135,051.44	74,129,838.67

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

11	Хувьцааны ногдол ашиг	0	0
12	Хүүгийн орлого	65,135,287.96	8,322,375.19
13	Төсөв байгууллагын өөрийн орлого	102,999,763.48	65,807,463.48
14	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102,426,663.48	65,286,363.48
15	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	573,100.00	521,100.00
16	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,273,931,600.00	26,341,804,800.00
17	Улсын төвлөрсөн төсвөөс	0	48,070,700.00
18	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	48,070,700.00
19	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,120,000.00	6,437,500.00
20	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	6,152,500.00
21	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,120,000.00	285,000.00
22	Төсвийн захирагчдаас	29,700,460,000.00	25,735,388,700.00
23	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,700,460,000.00	25,735,388,700.00
24	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	570,351,600.00	551,907,900.00
25	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	570,351,600.00	551,907,900.00
26	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,372,365,154.08	49,567,069,085.94
27	УРСГАЛ ЗАРДАЛ	47,372,365,154.08	49,567,069,085.94
28	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	539,941,986.48	544,063,997.60
29	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	396,257,697.74	400,181,013.52
30	Үндсэн цалин	296,185,891.74	296,269,628.52
31	Нэмэгдэл	80,295,806.00	84,179,385.00
32	Унаа хоолны хөнгөлөлт	14,376,000.00	14,332,000.00
33	Урамшуулал	5,400,000.00	5,400,000.00
34	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,311,150.90	52,909,815.10
35	Тэтгэврийн даатгал	33,008,884.42	36,608,301.07
36	Тэтгэмжийн даатгал	4,078,032.18	4,074,055.76
37	ҮОМШӨ-ний даатгал	3,259,467.07	3,259,244.61
38	Ажилгүйдлийн даатгал	813,633.99	814,811.15
39	Эрүүл мэндийн даатгал	8,151,133.24	8,153,402.51
40	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,640,149.00	37,420,758.45
41	Гэрэл, цахилгаан	2,505,049.00	2,318,381.35
42	Түлш, халаалт	32,917,500.00	33,001,617.10
43	Цэвэр, бохир ус	2,217,600.00	2,100,760.00
44	Хангамж, бараа материалын зардал	20,528,020.10	19,359,934.51
45	Бичиг хэрэг	4,525,935.00	4,553,057.00
46	Тээвэр, шатахуун	7,780,600.00	7,780,500.00
47	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,488,932.00	4,337,951.51
48	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	195,000.00	189,999.00
49	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,537,553.10	2,498,427.00
50	Эд хогшил, урсгал засварын зардал	2,659,030.00	5,652,127.28
51	Багаж, техник, хэрэгсэл	725,100.00	1,499,977.28
52	Урсгал засвар	1,933,930.00	4,152,150.00
53	Томилолт, зочны зардал	1,046,000.00	2,432,000.00

**Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

54	Дотоод албан томилолт	1,046,000.00	2,432,000.00
55	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,945,088.74	23,823,348.74
56	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,715,633.00	17,685,003.74
57	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,400,000.00	0
58	Даатгалын үйлчилгээ	1,049,988.00	1,044,867.00
59	Тээврийн хэрэгслийн татвар	112,800.00	25,080.00
60	Газрын төлбөр	207,936.00	103,968.00
61	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,733,520.00	4,964,430.00
62	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,725,211.74	0
63	Бараа үйлчилгээний бусад зардал	1,554,850.00	2,285,000.00
64	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,554,850.00	2,285,000.00
65	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,832,423,167.60	49,023,005,088.34
66	Бусад урсгал шилжүүлэг	41,374,548,951.52	43,889,687,054.84
67	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	41,313,835,722.33	43,840,006,292.27
68	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,149,500.00	12,130,183.00
69	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,694,129.19	36,663,879.57
70	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,869,600.00	886,700.00
71	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,457,874,216.08	5,133,318,033.50
72	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,457,874,216.08	5,133,318,033.50
73	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,921,646,524.91	1,555,179,296.12
74	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,921,646,524.91	1,555,179,296.12
75	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,320,813,149.52	4,242,459,674.43
76	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,242,459,674.43	5,797,638,970.55

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,498,310,000.00	44,388,999,672.87
2	УРСГАЛ ЗАРДАЛ	44,498,310,000.00	44,388,999,672.87
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	548,856,400.00	540,626,497.60
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	400,190,300.00	400,181,013.52
5	Үндсэн цалин	301,777,200.00	296,269,628.52
6	Нэмэгдэл	78,902,600.00	84,179,385.00
7	Унаа хоолны хөнгөлөлт	14,110,500.00	14,332,000.00
8	Урамшуулал	5,400,000.00	5,400,000.00
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,354,100.00	52,909,815.10
10	Тэтгэврийн даатгал	42,503,800.00	36,608,301.07
11	Тэтгэмжийн даатгал	3,962,600.00	4,074,055.76
12	ҮОМШӨ-ний даатгал	3,170,100.00	3,259,244.61
13	Ажилгүйдлийн даатгал	792,500.00	814,811.15
14	Эрүүл мэндийн даатгал	7,925,100.00	8,153,402.51
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,661,100.00	37,420,758.45
16	Гэрэл, цахилгаан	3,244,800.00	2,318,381.35
17	Түлш, халаалт	33,148,500.00	33,001,617.10

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

18	Цэвэр, бохир ус	2,267,800.00	2,100,760.00
19	Хангамж, бараа материалын зардал	19,523,700.00	19,359,934.51
20	Бичиг хэрэг	4,553,800.00	4,553,057.00
21	Тээвэр, шатахуун	7,780,600.00	7,780,500.00
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,490,500.00	4,337,951.51
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	198,800.00	189,999.00
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,498,427.00
25	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	2,499,627.28
26	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,499,977.28
27	Урсгал засвар	1,000,000.00	999,650.00
28	Томилолт, зочны зардал	2,467,300.00	2,432,000.00
29	Дотоод албан томилолт	2,467,300.00	2,432,000.00
30	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,159,900.00	23,823,348.74
31	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,982,500.00	17,685,003.74
32	Даатгалын үйлчилгээ	1,050,000.00	1,044,867.00
33	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	25,080.00
34	Газрын төлбөр	250,000.00	103,968.00
35	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,728,900.00	4,964,430.00
36	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00
37	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	2,000,000.00
38	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,949,453,600.00	43,848,373,175.27
39	Бусад урсгал шилжүүлэг	43,949,453,600.00	43,848,373,175.27
40	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	43,941,066,900.00	43,840,006,292.27
41	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,500,000.00	7,480,183.00
42	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	886,700.00	886,700.00
43	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	44,498,310,000.00	20,884,829,553.57
44	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,771,185,000.00	48,070,700.00
45	Улсын төсвөөс санхүүжих	8,771,185,000.00	48,070,700.00
46	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,727,125,000.00	20,801,802,437.39
47	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	35,727,125,000.00	20,801,802,437.39
48	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		34,956,416.18
49	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		34,435,316.18
50	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		521,100.00
51	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,242,459,674.43
52	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,797,638,970.55

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,437,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,437,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,437,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,152,500.00
210604	Урсгал засвар	3,152,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	285,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	285,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,437,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,437,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,152,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд богино хугацаат өр төлбөр, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Алтансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1-22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сан нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2021 оны 06 сарын 11-ний өдрийн хууль
- Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2021 оны 01 сарын 29 өдрийн хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сан 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 46,734.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 701.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 525.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,331.3 сая төгрөгөөр буюу 28.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,242.5	5,797.6	1,555.2
Авлага	3,333.6	4,127.5	793.9
Бараа материал	17.2	15.5	- 1.7
Үндсэн хөрөнгө	523.4	507.3	- 16.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,116.6</b>	<b>10,447.9</b>	<b>2,331.3</b>
Богино хугацаат өр төлбөр	233.7	168.4	- 65.3
Засгийн газрын оруулсан капитал	304.2	304.2	-
Хуримтлагдсан үр дүн	7,497.0	9,893.6	2,396.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	81.7	81.7	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>8,116.6</b>	<b>10,447.9</b>	<b>2,331.3</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,797.6 сая төгрөг болж 1,555.2 сая төгрөгөөр өссөн байна. НДЕГ-ын даргын 2017 оны А/51 тоот тушаалд заасны дагуу орон нутгийн нийгмийн даатгалын сангийн сарын үлдэгдлийг төсөвт зардлын 1.5 сараас хэтрэхгүй байхаар заасан бөгөөд тэтгэвэр тэтгэмжийн зардал өссөнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 4,127.5 сая төгрөг болж, 793.9 сая төгрөгөөр өссөн байна. Ковид цар тахлын үед ажил олгогч, даатгуулагчийн санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилгоор "Нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль" батлагдсан бөгөөд тус хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор үүссэн авлагыг татаас, санхүүжилтийн авлагаар тайлагнасан нь голлон нөлөөлжээ.

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 51,891.8 сая төгрөг болж өмнөх оноос 1,238.3 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, төвлөрүүлэх шилжүүлгийн орлогын данс байна. Тодруулбал тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 3,140.6 сая төгрөгөөр өссөн, төвлөрүүлэх шилжүүлгийн орлогын дүн өмнөх оноос 3,996.7 сая төгрөгөөр буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 49,495.0 сая төгрөг болж, өмнөх оноос 2,129.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, төвлөрүүлэх шилжүүлгийн зардлууд байна. Энэ нь нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал 2,483.2 сая төгрөгөөр өссөн, төвлөрүүлэх шилжүүлгийн зардал 323.3 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 47,158.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 47,158.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2,660.3 сая төгрөгөөр бууруулж 44,498.3 сая төгрөгөөр баталсан боловч тухайн байгууллагын 2021 онд хэрэгжүүлэх 47 ажил үйлчилгээ бүхий “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” 94.6 хувьтай хэрэгжсэн байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 44,498.3 сая төгрөгийн төсөв баталснаас 27,810.6 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс, 16,687.7 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр бусад эх үүсвэрээс 23,504.2 сая төгрөгийн санхүүжилт авч, нийгмийн даатгалын шимтгэлийн 20,884.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардалд 43,844.6 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 544.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 44,389.0 сая төгрөг буюу 99.8 хувьтай байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 6.4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 6.4 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 161 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл, мэдээлээгүй 12 мэдээлэл байгааг НДЕГ-ын дотоод хяналт

шалгалтаар илрүүлж, чиглэл хүргүүлсэн байна. Шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй 12 мэдээллийг нөхөн мэдээлсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын санд “Итгэл” үзүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сангийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар богино хугацаат өр төлбөр болон түлш халаалтын зардалтай холбоотой нийт 2 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:**

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулаагүй нь Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын 1 дэх “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуур суурилуулах ажлыг 2020 оны 3-р улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай” заалттай нийцэхгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

**2. Богино хугацаат өр төлбөртэй холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт:**

Санхүүгийн тайланд татварын өглөг, авлага тусгагдаагүй байхад татварын байгууллагын тодорхойлолтоор цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар 2,586.1 мянган төгрөгөөр илүү, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 55.0 мянган төгрөгөөр илүү, авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар 2.5 мянган төгрөгөөр дутуу, газрын төлбөр 41.6 мянган төгрөгөөр дутуу, автын агаарын бохирдлын төлбөр 3.5 мянган төгрөгөөр дутуу төлөлттэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Татварын байгууллагын тодорхойлолт дахь татварын илүү, дутуу төлөлтийг татварын байгууллагатай тооцоо нийлж, санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн нийгмийн даатгалын сан	2	-	-	-	-	-	-	-	2	-

/сая төгрөгөөр/